



**ХЭНТИЙ АЙМГИЙН
НОРОВЛИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/48

Норовлин сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн ээлжит гуравдугаар хуралдааны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Норовлин сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.1, 4.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүн болох багаасаа хөтөлбөрийн хүрээнд бага ангийн сурагчдын дунд зохион байгуулсан хүрд, тэгшитгэл, өгүүлбэртэй бодлого, эх зохион найруулан бичих олимпиадад шалгарсан сурагчдын шагналд 1055100 (нэг сая тавин таван мянга нэг зуу) төгрөгийг зарцуулсугай.

2. Төрийн албан хаагчдын дунд зохион байгуулсан монгол бичгийн олимпиадын шагналд 240000 (хоёр зуун дөчин мянга) төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх 1295100 (нэг сая хоёр зуун ерэн таван мянга нэг зуу) төгрөгийг мөрийн хөтөлбөрийн зардалаас зарцуулахыг нягтлан бодогч (П.Энхдорж)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Ө ДАВААЖАРГАЛ

